

Дорнод аймгийн МХБХолбооноос 2021-2022 онд  
хийсэн ажлын тайлан.

Илтгэгч: Холбооны тэргүүн .Нарангэрэл.

Дорнод аймаг дахь МХБХолбоо нь 9 бүлэг,74 гишүүнтэй Үүнээс : эрэгтэй 7, эмэгтэй 67, тэтгэврийн насны 61, ХБИ 4,өрхийн аж ахуй эрхэлдэг гишүүн 23, хувийн бизнестэй гишүүн 5, үр шим хүртэгч гэр бүлийн гишүүд 167 гэсэн бүрэлдхүүнтэй үйл ажиллагаагааявуулж байна.

**Нэг. Холбооны үйл ажиллагааны талаар**

Холбоо 2020-2021 онд холбоо болон зөвлөл, бүлгүүдээс хийсэн ажлын тайланг авч нэгтгэн дүгнээд тэргүүний бүлэг, зөвлөлүүдээ шалгаруулж шинэ жилийн баяраа тэмдэглэж шагнал урамшуулалаа гардуулсан. Тэргүүний зөвлөл тодроогүй, тэргүүний сайн ажилласан бүлгээр Есөн-Эрдэнэ бүлэг шалгарч , шилжин явах цом өргөмжлөл гардан авсан. Бүлгүүд тэргүүний гишүүдээ шалгаруулан цагаан өвгөний бэлгээр урамшуулсан. Шинэ жилийн баярын үйл ажиллагааг Есөн-Эрдэнэ бүлэг холбоо хамтран зохион байгуулсан. Нийт 58 гишүүн хамрагдсан. Зарим бүлэг бүх гишүүдээ бэлэг бэлдэж гардуулсан.

Шинэ он гармагц 1 сарын 10нд холбооны хурлаа хийж хуваарь гаргаж бүлгүүдийн хурлыг холбооны байранд хийлгэж 2022 оны ажлын төлөвлөгөөг гаргуулан хэвлэж өгснөөр бүх бүлэг жилийн ажлын төлөвлөгөөтэй болж , 2дахь хурлаараа холбооны ажлын төлөвлөгөөгөө хэлэлцэж баталсан.





Холбооноос Өсөх-Өгөөж бүлэгтэй хамтран “Ногоон хөгжилд хамтдаа” сэдэвт мод тарих технологийн сургалтыг нийт гишүүдийг оролцуулан хийж гарын авлага 2 төрлийн цэцгийн үр тарааж өгсөн.



Мөн Байгал Орчны Газраас зохион байгуулсан Мод бутны суулгацны үзэсгэлэн худалдаанд гишүүдээ хамруулсан ба гишүүн Б.Нарангэрэл нээлтийн ажиллагаанд үг хэлж 8 төрлийн суулгацтай оролцож мөн иргэдэд зөвлөгөө өгч оролцсон.



Аймгийн Хөдөлмөр Халамж Үйлчилгээний

Газартай гэрээ байгуулан Чойбалсан хотын төв талбай болох Тусгаар Тогтнолын талбайн болон төв замын 2талын мод бутыг хэлбэржүүлэн засах ажлыг 20 хүний бүрэлдхүүнтэй 20 хоногын хугацаанд хийж гүйцэтгэсэн





Өдөрлөг зохиож дараагийн бүлэгтээ шилжүүлэн өгөх ажлыг эхлүүлснээр одоо 6 дахь бүлэгтээ шилжээд байна. Үүний дүнд бүлгүүдийн дотоод ажил, холбооны хэмжээнд хийдэг бүтээлч ажлууд тогтмолжин үр өгөөжтэй болж байгаа.

Холбооны байрыг сарын 180,000 төгрөгөөр түрээслэн ашиглаж байна. Оны шилдэг бүлгээр шалгарсан Есөн-Эрдэнэ бүлгийн санаачлагаар Шилдэг бүлгийн цомоо 1 сарын хугацаатай бүлгүүдээр аялууулж уг бүлэг тодорхой ажлуудыг хийж тайлангаа тавьж

Цом Баялаг бүлгээс Өсөх-Өгөөж бүлэгт шилжиж байна. Өсөх-Өгөөж бүлэг өдөрлөгөөрөө гишүүдийн

дунд гар барилдааны тэмцээн, Есөн Эрдэнэ бүлэг АХА тэмцээн зохиов.





### Хоёр.Бүлгүүдийн үйл ажиллагааны талаар

3.Эрчулуун даргатай оны шилдэг Есөн-Эрдэнэ бүлэг, бүлгийн үйл ажиллагаагаа сурталчлах “Халуун цайтай уулзалт” өдөрлөг холбооны нийт гишүүдийг хамруулан хийж уламжлалт шагайн наадгай 4 төрөлт тэмцээнийг зохиосон.Бүлгийнхээ тэргүүний гишүүнд хадгалуулсан цомыг гишүүдийн гэр бүлээр аялуулж нэрэмжит ажил зохиож Эрчулууны гэр бүл 8 сорилго богино хугацааны тэмцээнийг бүлгийн гишүүдийнхээ дунд зохиосныхоо шагналыг гардуулж, дараагийн гишүүндээ цомоо шилжүүлэх ажлыг энэ үеэр хийв. Эдний бүлэг

хуримтглалаа сайн өсгөж зээл тогтмол гаргаж ажилласны дүнд Эрчулуун, Бадамсэд нар энэ жил бүлгээсээ зээл авч байраа засварласан байна. Мөн цар тахалтай байсан2021 онд гишүүдийнхээ эрүүл мэнд, дархлаагаа сайжруулахад нь зориулж бүлгийн хуримтлалаасаа тус бүр 500,000 төгрөгийн дэмжлэг



үзүүлсэн байна.



Бүлгийн оны шилдэг гишүүн



Бүлгийн хурал



Гишүүний төрсөн өдөр

Бүлгээсээ зээл авч байраа засварлалаа

Пүрэвсүрэн ахлагчтай Баялаг бүлэг бүх гишүүдээ хаш чулуун орны эмчилгээнд хамруулсан. УЗН-ийн онцгой гишүүнд 2 хүн шинээр элссэн Бүлгийн ажлаараа Дардас, чавх харвааны тэмцээн зохиосон, бүх гишүүдээ амралт сувилалын эрхийн бичиг авч өгсөн



Бүлгээрээ сувилалд



АХ-100 медаль хүртэв

Б.Энхтуяа даргатай Өсөх-Өгөөж бүлэг бүх өрхүүдээ жимсний мод нэмж тарих төлөвлөгөөнийхөө дагуу 4 өрх 6 төрлийн 50 ш жимсний мод нэгдсэн журмаар авч тариалсан. МАА бүхий 2 гишүүдийнхээ ажилд туслаж, аргал бууц бэлдэж гэр гэртээ, ногоо тариалдаг гишүүдээ буулгаж өгөх, мод үржүүлэх зорилгоор модны үр түүж гишүүн Энхтуяагийн 6м2 талбайд тарьж өгсөн. Нарангэрэл 30м2 газарт 4 төрлийн модны суулгац үржүүлж байгаа. Мод бутны үзэсгэлэн худалдаанд бүлгээрээ оролцсон. Цом аялах хугацааны бүтээлч гишүүнээ шалгаруулан урамшуулсан.





Өсөх-Өгөөж бүлэг нь цар тахлын дараагийн



дархлаажуулалтанд нь зориулж бүх гишүүддээ тус бүр 450,000 төгрөгийн



тэтгэлэг бүлгийн сангаасаа олгосон.



Байгал даргатай Баяжих бүлэг Бүлгээрээ Мойлтын Тохой амралтанд амарсан. Гишүүн Бямбасүрэнгийн хашааг нь сэлбэн засаж тусалсан. Эрүүл зан үйлийг хэвшүүлж “Эмгүйгээр эрүүлжье, алхангаа ярилцья аянд нэгдэж өглөө бүр 05-07 цагын хооронд бүлгээрээ алхалт хийж хэвшсэн. Гишүүдийнхээ төрсөн өдрийг бүтээлч хэлбэрээр хийдэг болсон.

И.Цэцэгмандал даргатай Дорнын гэгээ бүлэг 4 гишүүн шинээр элсүүлж бүлгийн ажлаа тогтмолжуулсан. Ногоо тариалдаг 2 гишүүнийдээ хаврын тариалалт, зуны арчилгааны ажилд нь 2 удаа очиж тулсан. Холбоо болон бүлэг зөвлөлүүдээс зохиож байгаа ажлуудад идэвхитэй оролцож байгаа.



Баялаг бүлгийн зохиосон тэмцээнд бүлгээрээ дэд байранд орсон

Т.Цэрмаа даргатай Арвижих бүлэг сарын хуримтлалаа 20,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн. 2 гишүүн шинээр элсүүлсэн. 3 удаа бүлгийн хурлаа хийсэн ХОХС-д гишүүнчлэлээ хугацаанд нь төлж байгаа. Тэнгэрлэг гэр бүлээр шалгарсан Бүрэнжаргал, Оюун нарын гэр бүлд хүндэтгэл үзүүлж бэлэг дурсгалын зүйл гардуулсан. Холбоо бүлгүүдээс зохиосон

ажлуудад тогтмол идэвхитэй оролцдог. Цэрмаа нь эрүүл мэндийн зөвлөлийн даргаар ажиллаж энэ онд ХХҮГ-ын шугамаар ирсэн ахмад болон ХБИ-ийн сонголт шалгаж аппарат үнэ төлбөргүй олгодог групп үзлэгийн тухай мэдээллийг гишүүдэд хүргэж улмаар 3 бүлгээс 3 гишүүнийг хамруулсан байна.







Бүлэг цом хүлээж авлаа



Бүрэнжаргал АХА тэмцээнд түрүүлэв

Б.Гандолгор даргатай Дэлбээ бүлэг Холбооны анхны бүлгүүдийн нэг үйл ажиллагаа хэвийн явж байна.

Оюунчимэг даргатай Мөнгөн жигүүр бүлэг 10 гишүүнтэй энэ онд шинээр байгуулагдсан. Холбооноос зохиогдсон ажлуудад идэвхитэй сайн оролцож байна.



10 гишүүнтэй Мөнгөн жигүүр бүлэг

**Дөрөв. Гишүүдийн оролцоо  
манлайлал чадавхижилт**



Холбоо болон бүлэг зөвлөлүүдээс зохион байгуулсан ажлуудад гишүүд маш идэвхитэй оролцож байгаа.Арвижих бүлгийн гишүүн Бүрэнжаргал,Оюун нар өрхийн аж ахуйгаа эрхлэхийн зэрэгцээ энэ онд Тэнгэрлэг нэр бүлээр шалгарсан. Мөн Цэцэгмандал Зоригт нар багын иргэд дундаас Тэнгэрлэг гэрээ бүлээр шалгарснаар манай холбоо 2 Тэнгэрлэг гэр бүлтэй болж бид их баяртай байгаа.



Мөн Ардын хувьсгалын 100,110 жилийн ойн баяр наадмаар 23 гишүүн 100 жилийн ойн медаллаар, М.Мягмар алтангадас одонгоор энэ онд шагнагдсан. Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд МУ-ын засгийн газраас санаачлан 1000-н сургагч багш бэлтгэх хөдөлгөөнд хамрагдаж Б.Нарангэрэл сургагч багш болсон. Мөн Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан Агрономчдын улсын 2-р зөвлөгөөнд Б.Нарангэрэл, Нийтийн ахуй Үйлчилгээний хоршоологчдын улсын зөвлөгөөнд

Л.Алтанцэцэг нар төлөөлөгчөөр сонгогдон оролсон байна. И.Цэцэгмандал 5 дахь жилдээ алхалтаар хичээллэж ахмад залуу үеийг үлгэрлэж байна. Олон гишүүд ахмадын болон баг хорооны идэвхитэн сонгуультнаар ажиллаж байна.



**Тав. Дүгнэлт, тулгамдаж байгаа асуудал.**

Бүлгүүдийн үйл ажиллагааны хувьд Чогжмоо даргатай Ургах наран бүлэг янз бүрийн шалтаг шалтгааны улмаас гишүүд нь цөөрч үйл ажиллагаа нь зогсонги байдалтай байгааг тооцохгүй бол бусад бүлгүүд хэвийн тогтмол ажиллаж байна. Холбооны байрандаа сард 180,000 төгрөгийн түрээс төлдөг болсон нь хүндрэлтэй болсон. Ашиглалт бол сайн байгаа.